БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2023 оны 12 дугаар сарын 27 өдөр

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СОЁЛЫН ОРДНЫ БАРИЛГЫН ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖИЛ (19 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| **1** | Төсөл боловсруулах үндэслэл | - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний 26 дугаар тогтоол. |
| **2** | Байршил, барилгын хэмжээ | - Хан-Уул Дүүргийн 19 дүгээр хороо, Соёлын ордны барилга |
| **3** | Зориулалт хүчин чадал | - Хан-Уул Дүүргийн 19 дүгээр хороо, Соёлын ордны барилгын дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэх<br>- Гүйцэтгэгч байгууллага зургийн шатанд илүү дэлгэрэнгүй талбайн судалгаа, хэмжилтийг хийж нарийвчлах. |
| **4** | Одоогийн байдал | - Барилгын дээврийн хучлага төмөр ан зааг орсон<br>- Дээврийн төмөр зэвэрч муудсан. |
| **5** | Төсөл гүйцэтгэх хугацаа | - Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно. |
| **6** | Төслийн захиалагч | - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| **7** | Төсөл гүйцэтгэх байгууллага | - Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан гадна, дотор засал чимэглэл, орчны тохижилтын зураг төсөв боловсруулах болон ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж оролцох боломжтой. |
| **8** | Төсөл гүйцэтгэх үе шат | - Талбайн судалгааг газар дээр нь хийж ус нэвчилттэй хэсэгт засвар хийхээр ажлын тоо хэмжээг гарган ашиглагч болон захиалагчтай зөвшилцөх<br>- Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/.<br>- Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. |
| **9** | Төлөвлөлтөд тавигдах шаардлага | **<u>Шинээр хийгдэх ажил:</u>**<br>- Шувуу нуруун дээврийн хэвлэмэл төмрийг шаардлагатай байршлуудад засварлан, шаардлагатай тохиолдолд шинээр солих. |
| **10** | Төсөл боловсруулахад ашиглах материал | **<u>Монгол Улсын хуулиуд</u>**<br>- Хот байгуулалтын тухай хууль<br>- Барилгын тухай хууль<br>- Бусад холбогдох хууль<br>**<u>Норм, нормативууд:</u>**<br>- Дээврийн ажил /БНбД31-07-05/<br>- БД 31-108-08 |

| | | |
|---|---|---|
| | | - Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05<br>- БД 23-103-10 Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт<br>- MNS 3154-1981 40мм хүртэл диаметртэй арматуран гагнасан тор. Ерөнхий техникийн шаардлага<br>- MNS 6303:2016 Дээвэр болон барилга байгууламжид хэрэглэх ус, уур тусгаарлах хуйлмал материал.Техникийн ерөнхий шаардлага<br>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>- Бусад холбогдох норм, дүрэм |
| **11** | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | - Дээврийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх. |
| **12** | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох. |
| **13** | Онцгой нөхцөл | - Дээврийн засварын ажилд хэрэглэгдэх материалууд нь бүгд гарал үүслийн гэрчилгээтэй, барилгын материалын лабораториор баталгаажсан сертификаттай, монгол улс болон олон улсын чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан байх.<br>- Засварын ажилд хэрэглэгдэх машин механизмын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах<br>- Өндөрт ажиллах ХАБЭА-н дүрэм, журмыг чанд мөрдөх. |

- Энэхүү ажил нь соёлын ордны дээврээс ус нэвчдэг байдлыг бүрэн засварлаж, үйл ажиллагаа хэвийн явуулах зорилготой.
- Соёлын ордны дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах.
- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд ажлын зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.
- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНбД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ЛУВСАНЖАМЪЯН